



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

“Дулаан шарын гол” төрийн өмчит
хувьцаат компанийн эздийн өмч дэх
төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэх, дүрэмд
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалт, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 4,254,280,132.00 (дөрвөн тэрбум хоёр зуун тавин дөрвөн сая хоёр зуун наян мянга нэг зуун гучин хоёр) төгрөгийн хөрөнгийн дүнгээр “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн эздийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлсүгэй.

2. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3.1-т “Компанийн зарласан хувьцаа нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 17,813,363.00 (арван долоон сая найман зуун арван гурван мянга гурван зуун жаран гурван) ширхэг энгийн хувьцаатай байна...” гэснийг “Компанийн зарласан хувьцаа нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 65,259,940.00 (жаран таван сая хоёр зуун тавин есөн мянга есөн зуун дөчин) ширхэг энгийн хувьцаатай байна...” гэж өөрчилсүгэй.

3. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал Б.Энхцэцэгт даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002100